

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

"Замын-Үүд" чөлөөт бүсийн Захирагчийн
ажлын алба

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын
хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Үйлдвэр, тээвэр, логистикийн бодлого
хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-8

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж, 4-р хороо, Засгийн
газрын XI байр /Дорноговь аймгийн
Замын-Үүд сум, Замын-Үүд чөлөөт бүс/

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Чөлөөт бүсийн тухай хуулийг хэрэгжүүлэх, Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах үйлдвэр, логистик, зам талбай, тээврийн сүлжээний харилцааг зохицуулах, барилга угсралтын ажилд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу үйлдвэр, тээвэр, логистикийн бодлогыг хөгжүүлэх санал, дүгнэлт боловсруулах, бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгуулах;

2.Барилга угсралтын ажилд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдүүлэх, олон улсын тээвэр зуучийн үйл ажиллагаанд болон барааны гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлтэд хяналт тавих, нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.Хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу үйлдвэржилт, тээвэр, логистикийн бодлогыг хөнгөвчлөх бодлого боловсруулах, дүрэм, журам санал дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах;	Үйлдвэр, худалдаа логистикийн бодлого хэрэгжих суурь бий болсон байна.	Т, Г
	2.Үйлдвэр, тээвэр логистикийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж хэрэгжүүлэх.	Чөлөөт бүсэд тээвэр, логистикийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна.	Т, Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Чөлөөт бүсэд үйлдвэр, тээвэр логистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн үйлдвэржилт, олон улсын тээвэр зуучлал, логистикийн үйл ажиллагаанд хяналт тавих;	Чөлөөт бүсэд тээвэр, логистикийн үйл ажиллагаа тогтворжино.	Г
	2.Гаалийн байгууллагатай хамтран аж ахуйн нэгж байгууллагуудын бараа, бүтээгдэхүүний гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлтийг шуурхай хөнгөвчилсөн байдлаар хийхэд дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөмжөөр хангах.	Гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлт шуурхай хөнгөвчилсөн байдлаар хийгддэг болно.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, сар, улирал, хагас, бүтэн жилээр тайлагнах;	Төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хэрэгжсэн байна.	Г

	2.Албан тушаалын чиг үүрэгт хамаарах чиглэлээр архивын нэгж үүсгэх, албан хэргийг стандартын дагуу хөтлөх;	Архив, албан бичгийн хөтлөлт стандартын шаардлага хангасан байна.	Г, Т
	3.Хариутай бичгийг цаг алдалгүй шийдвэрлэх, хариуг уламжлах, цаг үеийн шаардлагаар удирдлагаас өгсөн болон удирдлагын шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах.	Төлөөлөгөөнд тусгагдсан ажлууд хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- менежмент ба удирдахуй /041301-041305, 041308/ - эдийн засаг /0311/ - иргэний ба үйлдвэрлэлийн барилга, байгууламж /073201-073205, 073207/ - тээврийн үйлчилгээ /104101/.
Мэргэшил	-
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Чөлөөт бүсийн чиглэлээр мэдээлэл цуглуулах, мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - чөлөөт бүсийн чиглэлээр хариуцан гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - чөлөөт бүсийн салбарын асуудлын хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - чөлөөт бүсийн салбарын асуудлаар судалгаа хийж дүнг хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зарчимч, тууштай байх; - ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;

